



Шинжээчийн тайлан

(Магистрын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл)

Байгууллагын нэр: ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Утасгүй холбооны инженерчлэл /магистр/

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Оюунсүрэн

Гишүүд: Р.Мижиддорж

Д.Сумъяаханд

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны Технологийн сургуулийн Холбооны салбар Mongolian University of Science and Technology – School of Information and Communication Technology	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Утасгүй холбооны инженерчлэл Wireless Communication Engineering	
Индекс	E071408	
Шинжээчид	<ul style="list-style-type: none"> • Б.Оюунсүрэн: Ургах цаг нийгэмлэгийн санхүүгийн боловсролын зөвлөх багш, доктор, дэд проф • Р.Мижиддорж: МУБИС-ийн Математик байгалийн ухааны их сургуулийн мэдээлэл зүйн тэнхимийн багш, доктор, дэд проф • Д.Сумъяаханд: МУИС-ийн Мэдээллийн технологи, электроникийн сургуулийн Электроник холбооны инженерчлэлийн тэнхимийн ахлах багш, доктор 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	01 сарын 31	Шинжээчийн багийг томилох
	02 сарын 02	Өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн багийн гишүүдэд хүлээлгэн өгөх, багийн уулзалт хийх
	02 сарын 13	Урьдчилсан үнэлгээний тайланг сургуульд хүргүүлэх
	02 сарын 15-16	Шинжээчийн баг сургууль дээр очиж ажиллах
	02 сарын 23	Шинжээчийн багийн тайланг сургуульд хүргүүлэх
	2024/02	Сургуулиас саналыг авч, Шинжээчийн багийн тайланг БМИҮЗ-ийн ажлын албанд хүргүүлэх
	2024/03	Комиссын хурлаар хэлэлцүүлэх
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, 2020 оны 04 дүгээр сарын 13-ны 06 тоот тогтоолоор баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол улсын холбооны салбарт 1960-аад оноос хийгдэж байсан бүтээн байгуулалт техникийн шинэчлэлүүд нь үндэсний боловсон хүчнийг бэлтгэх хэрэгцээ тулгамдаж, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор 1967 онд МУИС-ийн радиофизикийн ангийн 25 оюутныг Энерги механикийн факультетад шинээр нээгдсэн холбооны инженерийн ангид шилжүүлэн суралцуулснаар тус сургуулийн суурь тавигдсан. МУИС-ийн Ректорын 1971 оны 21 тоот тушаалаар Политехникийн Дээд сургуулийн Эрчим хүчний Факультетын бүрэлдэхүүнд радио холбооны тэнхимийг 6 багштайгаар байгуулсан түүхтэй. Энэхүү тэнхим нь жил бүр радио холбоо, цахилгаан холбоо гэсэн 2 мэргэжлээр инженерүүдийг бэлтгэж ирсэн.

2002-2003 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд мэргэжлийн тэнхимийн зохион байгуулалтаас судалгааны профессорын багийн зохион байгуулалт руу шилжих үед Радио холбооны тэнхим нь утасгүй холбоо ба өргөн нэвтрүүлгийн технологийн 2 судалгааны баг болж зохион байгуулагдсан. Боловсролын шинэчлэлийн хүрээнд ШУТИС судалгааны профессорын багийн бүтцээс салбарын бүтцэд шилжсэн 2014 оноос Холбооны салбар магистрын 6 хөтөлбөрөөр ахисан түвшний сургалт явуулж байна.

Шинжлэх ухаан боловсролын сайдын 1996 оны 03 сарын 09-ны өдрийн 84 тоот тушаалаар батлагдсан “Радио холбоо” мэргэжлээр МХТС-ийн Радио холбооны тэнхим нь магистрын сургалт явуулж эхэлсэн. 2009 оноос Радио холбоо мэргэжлийн нэрийг “Утасгүй холбоо” хэмээн өөрчилсөн байдаг. Улмаар БШУС-ийн 2014 оны А/370 тоот тушаалаар “Утасгүй холбооны технологи” нэртэй хөтөлбөр болж өөрчлөгдсөн. Одоо БШУС-ийн 2022 оны А/160 тоот тушаалаар “Утасгүй холбооны инженерчлэл” нэрээр сургалт явуулж байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд 198 оюутан элсэж, 136 магистрын зэрэг хамгаалж төгссөн.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна

1.1 Хөтөлбөрийн боловсруулалт

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- Алсын хараа- 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- ШУТИС 2030 стратеги төлөвлөгөө

- ШУТИС-ийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам
- ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцоо
- Төгсөгч, ажил олгогчдын уулзалтын үр дүн
- Хөтөлбөрийн дэд хорооны 2018 оны 3-р сарын 23-ны өдрийн хурлын протокол

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг боловсруулахдаа оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг улс орны урт болон богино хугацааны хөгжлийн бодлого, ШУТИС-ийн стратеги төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан иж бүрэн боловсруулсан.
- Чанарын менежментийн алба болон тогтолцоотой.
- Хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, хөтөлбөрийг сайжруулах зэрэг үйл ажиллагааг журмаар зохицуулдаг.
- Оролцогч талууд буюу төгсөгч, ажил олгогчдын саналд нийцүүлэн хөтөлбөрөө сайжруулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хяналт шинжилгээг тогтмолжуулахад анхаарах.

Дүгнэлт: Хөтөлбөрийг салбарын хөгжил, зах зээлийн эрэлт, оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц иж бүрэн боловсруулж, хянан сайжруулдаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрт хяналт шинжилгээ хийсэн үр дүн болон оролцогч талуудын санал, зөвлөмжийг хөтөлбөрийг сайжруулахад хэрхэн тусгасан талаар баримтжуулан, хяналтыг тогтмолжуулах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгч, ажил олгогчдын уулзалтын үр дүн
- SOEP Technological University PEOs
- ОУЛУ-ын Их сургуулийн Утасгүй холбоо ахисан түвшний хөтөлбөрийн зорилго
- ШУТИС 2030 стратеги төлөвлөгөө
- МХТС эрхэм зорилго, алсын хараа

Онцлог зүйл:

- “Утасгүй холбооны инженерчлэл” магистрын хөтөлбөрийн зорилго нь ШУТИС болон МХТС-ийн алсын хараа эрхэм зорилготой уялдаа холбоо сайн.
- Олон улсын хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг тусгасан.
- Гадны магадлан итгэмжлэлийн байгууллага (АВЕТ)-ын зөвлөмжийг тусгаж хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөр нь хэрэгжиж эхэлснээс хойш хөтөлбөрийн зорилгод үнэлгээ, судалгаа хийж байсан тухай, хэрэв сайжруулсан бол үндэслэлийг баримтжуулан, тайлбарлах
- Өөрийн сургуулийн магистрын хөтөлбөрийн бусдаас ялгарах онцлог, давуу талыг илүү тодорхой тусгах

Дүгнэлт: Хөтөлбөрийн зорилго нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн, глобал хөдөлмөрийн зах зээл, ирээдүйн хандлагыг тусгасан бөгөөд агуулга, найруулга, үг зүйн хувьд зөв тодорхойлогдсон байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилгыг хянах, үнэлэх, сайжруулах үйл ажиллагааг системтэйгээр хийж, оролцогч талуудын саналыг тусган эргэх холбоог идэвхжүүлэх.
- Мэргэжлийн болон судалгааны магистрын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хөтөлбөрийн онцлогийг тусгаж ялгаатай тодорхойлох.

1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2023 оны 6-р сарын 7-ны өдрийн А/202 Ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай тушаал
- Хөтөлбөрийн дэд хорооны 2023 оны 10-р сарын 3-ны хурлын протокол
- Батлагдсан сургалтын төлөвлөгөө
- Ажил олгогч, төгсөгч, багш нарын уулзалтын үр дүн
- Хичээлийн батлагдсан хөтөлбөрүүд
- Э.Эрдэнэтуяа, З.Буяншиг, Ж.Жавзансүрэн багш нарын хичээлийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний тайлан, хичээлийн тайлан
- ОУЛУ-ын Их сургуулийн Утасгүй холбоо ахисан түвшний хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн нь Юнеско-ийн боловсролын 4 тулгуурт зарчимтай уялдаа хамааралтайгаар тодорхойлогдсон.
- 2023 оны шинэчилсэн төлөвлөгөөнд тухайн салбарын ирээдүйн хандлагыг тусгаж, ажил олгогч төгсөгчдийн хэрэгцээ шаардлагын дагуу шинэ хичээлүүдийг нэмж оруулсан.
- Магистрант сонирхсон чиглэлээр дагнан мэргэших боломжтой байдлаар заавал судлах болон сонгон судлах хичээлүүдийн харьцааг төлөвлөсөн

Анхаарах асуудал:

- Магистрын судалгааны ажил төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах

Дүгнэлт: Хөтөлбөрийн агуулга нь онол практикийг зохистой хослуулсан, суралцахуйн үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Магистрын судалгааны ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хянаж шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг нөхцөл байдалд тохируулан өөрчлөх.

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн батлагдсан хөтөлбөрүүд
- Хөтөлбөрийн дэд хорооны протокол

Онцлог зүйл:

- Улирал бүр багш хичээлийн тайлан хийдэг бөгөөд түүнд хичээлийн суралцахуйн үр дүнд дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол хичээлийн агуулга, бүтэц, үнэлгээний арга зэргийг шинэчлэн сайжруулдаг.
- Салбарын хөгжлийн онцлогт тохируулан хичээлийн агуулгыг тасралтгүй сайжруулж, шинэчилдэг.
- Хичээлийн суралцахуйн үр дүн, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдаа холбоо сайн.

Анхаарах асуудал:

- Зарим хичээлийг судалсан магистрантын тоо хэт цөөн тул суралцахуйн үр дүнгийн анализ зарим тохиолдолд буруу гарах магадлалтай.

Дүгнэлт: “Утасгүй холбооны инженерчлэл” магистрын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд багтсан хичээлүүдийн агуулга хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн, хичээл бүрийн суралцахуйн үр дүн нь хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй уялдаа холбоотой байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Ажил олгогч, төгсөгч болон оюутнуудаас авсан санал асуулгын дүнг сайтар баримтжуулан, дүн шинжилгээ хийж хичээлийн хөтөлбөрийг сайжруулах үндэслэлийг тодорхойлох.

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Ажил олгогчидтой хийсэн уулзалтын үр дүн

- Монгол улсын дээд боловсролын тухай хууль

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг тухайн салбарын ирээдүйн чиг хандлагатай нийцүүлэн 2023 онд шинэчилсэн.
- Ажил олгогчид төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар, манлайлах чадварт сэтгэл хангалуун байдаг.
- Жил бүр “Career development” нэртэй ажил олгогч, оюутан, магистрантуудын өдөрлөгийг зохион байгуулж, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог.

Анхаарах асуудал:

- Олон улсад тухайн хөтөлбөрт ямар тусгай шаардлагуудыг тавьж байгааг судлах

Дүгнэлт: Хичээлүүдийн суралцахуйн үр дүн нь хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнг хангахад чиглэсэн бөгөөд нарийвчилсан, ерөнхий болон төрөлжсөн чиглэлээр мэдлэг, хандлага, чадварыг олгодог.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Олон улсад тухайн хөтөлбөрт ямар тусгай шаардлагуудыг тавьж байгааг судалж баримтжуулан, хэрэгжүүлэх боломжтой үр дүнтэй аргуудыг туршиж, хэрэгжүүлэх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчныг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцөлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- Elself.edu.mn
- ШУТИС-ийн захирлын 2023 оны 6-р сарын 7-ны өдрийн А/202 Ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай тушаал
- Оюутнуудтай хийсэн уулзалтын үр дүн

Онцлог зүйл:

- Элсэлтийн мэдээлэл, процесс зэрэг нь ШУТИС-ийн нэгдсэн вебээр хийгддэг, нийтэд ил тод.

- IELTS, TOEFL зэрэг олон улсын хэлний түвшин тогтоох шалгалтын тодорхой түвшин бүхий бүртгүүлэгчийг шалгалтын хүчинтэй хугацаанд нь гадаад хэлний шалгалтаас чөлөөлдөг.
- Бүртгүүлэгч ШУТИС-ийн бакалаврын зэргийг 2.5-аас дээш голч дүнтэй төгссөн бол элсэлтийн шалгалтгүйгээр, 2.0 ба түүнээс дээш голч дүнтэй төгссөн бол зөвхөн мэргэжлийн ярилцлагад орж элсэх боломжтой.
- Мэргэжлийн ярилцлагыг зайнаас авах боломжтой байдаг ба энэ нь бүртгүүлэгчдэд таатай байдаг.

Анхаарах асуудал:

- Магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, дэмжих хэлбэр хэмжээг тодорхой, ил тод мэдээллэх.

Дүгнэлт: Тухайн хөтөлбөрт элсэгчид тавигдах шаардлага нь ил тод, шударга бөгөөд элсэгчийн бакалаврын хөтөлбөрт суралцаж төгссөн голч дүнгээс хамааруулан хөнгөлөлттэй байдлаар элэх боломжийг олгодог. Судалгааны ажлын сэдэв, удирдагч сонгох үйл явц тодорхой.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Магистрантыг элсэхэд нь судалгаа хийх санхүүжилт, хийсэн судалгаагаа бусдад танилцуулах, хэлэлцүүлэхэд санхүүгийн хувьд дэмжих, тухайлбал удирдагч багшийн төслийн багт судлаачаар ажиллах, эрдэм шинжилгээний хурлын зардлыг сургуулиас төлөх гэх мэт боломжууд бийг ил тод, тодорхой мэдээллэх.

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнууд, төгсөгчид, ажил олгогчидтой уулзсан уулзалтын үр дүн
- Сургалтын батлагдсан төлөвлөгөө
- Cloud Unimis систем

Онцлог зүйл:

- Онолын хичээлийг зайнаас MS teams болон Moodle платформ дээрх цахим хичээлээс үзэх боломжтой бөгөөд практик дадлага, лабораторийг магистрант өөрийн цагийн хуваарьт тааруулан хийх боломжоор хангадаг.
- CLOUD UNIMIS систем нь хэт их, эсвэл хэт цөөн хичээл сонгохыг дэмждэггүй учир ачаалал жигд хийхээр тохируулагдсан.
- Тухайн улиралд орох хичээлийн саналыг оюутнуудаас авч, уян хатан байдлаар хичээл сонголтыг хийлгэдэг.
- Сургуулиас хичээл сонголт, хурал зэргийн зарыг цахим шуудангаар болон утсаар холбогдож тогтмол мэдээллэдэг.

Дүгнэлт: Тус хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хичээл сонголтын процесс, сургалтын дүрэм журам, хичээлийн хуваарийн уян хатан зохицуулалт нь магистрантын ачааллыг суралцах хугацаанд нь жигд байхаар зохицуулагдсан бөгөөд энэ нь магистрантыг хэвийн хугацаанд сурч төгсөхөд нь дэмжлэг болдог байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Магистрантын судалгааны ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаад хяналт тавих.

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нартай уулзсан уулзалтын үр дүн
- <https://elearn.sict.edu.mn/>
- Багш нарын мэдээлэл
- Холбооны салбарын хичээлийн жилийн тайлангууд

Онцлог зүйл:

- Анх багшаар ажилд орж байгаа хүн бүрийг багшлах эрхийн сургалтад суулгадаг.
- Moodle платформ дээр бакалаврын болон ахисан түвшний, нийт 90 гаруй цахим хичээлийг байршуулсан.
- Ёс зүйтэй судлаачийн үүднээс, магистрантууд ШУТИС-ийн дотоод сүлжээнээс хандах боломжтой албан ёсны 11 сан, мөн багш нарын IEEE гишүүнчлэлийн эрхээр эрдэм шинжилгээний бүтээлтэй танилцах боломжтой.

Анхаарах асуудал:

- Суралцагч төвтэй, идэвхтэй сургалтын тодорхой аргуудаас туршиж, багшлахуйн арга зүйг тогтмол сайжруулах

Дүгнэлт: Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Орчин үеийн шинэлэг арга хэрэгсэл турших, олон улсын туршлага судлах гэх мэт багшлахуйн арга зүйг сайжруулах тодорхой ажлуудыг төлөвлөж, тогтмол хийх.

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан үялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын

судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах үр чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан сургалтын төлөвлөгөө
- Оюутнууд, төгсөгчдийн уулзалтын үр дүн
- ШУТИС-ийн захирлын 2023 оны 6-р сарын 7-ны өдрийн А/202 Ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай тушаал
- ШУТИС-д магистр, докторын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам

Онцлог зүйл:

- Магистрантыг элссэн улиралд нь судалгааны ажлын удирдагчийг томилдог бөгөөд удирдагч болон сэдвээ сонгох эрх нь нээлттэй.
- Магистрант элссэн улирлаас эхлэн судалгаа шинжилгээ, инновац бүтээх үр чадвар эзэмшүүлэх зорилготой хоорондоо логик холбоотой нийт 12 кредитийн хичээлийг судалдаг.
- Судалгааны сэдвийг магистрант өөрийн сонирхож буй сэдвээр чөлөөтэй сонгох боломжтой.

Анхаарах асуудал:

- Магистрант анх элсэхдээ хийсэн судалгааны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт сул

Дүгнэлт: Магистрантын удирдагч томилох тодорхой журамтай бөгөөд магистрантын судалгааны үр чадварыг тодорхой хичээлүүдээр эзэмшүүлэн, магистрантын судалгааны ажлыг чанаржуулахын тулд судалгааны ажлын журмаар зохицуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Магистрант анх элсэхдээ сонгосон сэдэв, хийсэн төлөвлөгөөнд удирдагч тогтмол хяналт тавьж, магистрантыг идэвхжүүлж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг өөрчилж, магистрантыг төлөвлөсөн хугацаандаа, чанартай судалгааны ажил хийж дуусахад нь дэмжлэг үзүүлэх.

2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнуудтай хийсэн уулзалтын үр дүн

- ШУТИС-ийн захирлын 2023 оны 6-р сарын 7-ны өдрийн А/202 Ахисан түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай тушаал
- ШУТИС-ийн захирлын 2018 оны 03-р сарын 16-ны өдрийн А/48 тушаал- ШУТИС-ийн технологи дамжуулах журам
- ШУТИС, МХТС ажлын тайлан 2022-2023

Онцлог зүйл:

- Эрдэм шинжилгээний үйл ажиллагааны зарыг цахим шуудангаар болон сургуулийн веб, мэдээллийн самбарт тогтмол мэдээллэдэг бөгөөд суух болон оролцох тохиолдолд зардлыг сургууль хариуцдаг.
- Судлаач магистрант удирдагчийн удирдлага дор 1-ээс доошгүй өгүүлэл бичиж, хуралд илтгэх шаардлага тавьдаг бөгөөд сэтгүүл, хурлын сонголтыг чөлөөтэй хийлгэдэг.
- Бүтээлч ажил, шинэ бүтээл патент, ашигтай загвар зэргийг дэмжих технологи дамжуулах тухай журамтай.
- Оюутнуудын бүтээлч ажлыг дэмжихээр Эрдэм шинжилгээний эмхэтгэл, олон улсын ICT focus гэсэн сэтгүүлүүдийг салбар нь эрхлэн гаргадаг.
- Магистр докторын оюутнуудын дунд “Мэдээлэл холбооны салбарт бидний гүйцэтгэх үүрэг” нэртэй эрдэм шинжилгээний хурал зохиодог.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын бүтээлч ажлыг урамшуулах тодорхой тогтолцоотой байх.

Дүгнэлт: Магистрант нь өөрийн судалгааны ажлыг нийтэд таниулах, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны арга хэмжээ, бага хуралд оролцоход нээлттэй бөгөөд сургуулийн зүгээс санхүү, судалгааны бааз, нөхцөл орчин, мэдээллээр хангаж удирдан чиглүүлж ажилладаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Магистрантын бүтээлч ажлыг дэмжих, үнэлэх, урамшуулах тодорхой тогтолцоог боловсруулж, хэрэгжилтийг хангах.

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр
- Төгсөлтийн баримт бичиг,
- Дүнгийн анализ.

Анхаарах асуудал:

- PLOs хэт ерөнхий, бакалавр түвшинд уг шалгууртай холбоотой ажил тогтмол хийгдэж хэвшсэн.

Дүгнэлт: Бакалаврын түвшинд авч хэрэгжүүлж байгаа түвшинд хүргэх шаардлагатай.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Бакалаврын түвшинд хэрэгжиж хэвшсэн ажлуудыг магистрын түвшинд хэрэгжүүлж хэвших.

Шаардлага:

- Суралцахуйн зорилт хэт ерөнхий байгаа нь үр дүнд амжилттай хүрсэн эсэх шалгуур нь бусад хөтөлбөрүүдтэй адилхан байна. Яг энэ хөтөлбөрийн онцлогийг харуулсан PLO тодорхойлж түүндээ хүрч байгаа эсэхийг шалгадаг байх.

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2008 оны 4 сарын 01-ны “Магистрын шилжилт хөдөлгөөний журам”-н дагуу зохицуулдаг.

Онцлог зүйл:

- Өөр хөтөлбөрт шилжин суралцдаггүй, харин өөр хөтөлбөрөөс тус хөтөлбөрт шилжиж суралцдаг.

Дүгнэлт: Шилжилт хөдөлгөөний журмын дагуу үйл ажиллагаа хэвийн явагддаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх багшийн үйл ажиллагаа, магистр оюутны асуумж 2019-2020 он.
- ШУТИС-ийн захирлын 2022 оны 4 сарын 15-ны А/106 тоот “Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”-н дагуу оюутны санал гомдлыг шийдвэрлэдэг. <https://must.edu.mn/media/uploads/2022/11/28/dqhaag.pdf>
- “Ажил олгогчдын өдөрлөг”-ийн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр

Онцлог зүйл:

- Мэдээллийг Gmail хаяг болон бусад хэлбэрээр тогтмол илгээж хэвшсэн.

Дүгнэлт:

Дотуур байранд суухаас бусад үзүүлэлт хэвийн явагдаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Оюутны дотуур байранд суух боломж байхгүй байгааг анхаарах.

3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-н Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам 2018.12.18-ны А/248.

Онцлог зүйл:

- Багш нарын судалгааны багаар ажиллахыг дэмждэг.

Анхаарах асуудал:

- Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа судалгааны ажилд тус хөтөлбөрөөр суралцагчдыг татан оролцуулах тал дээр хангалтгүй.
- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад төсөв гаргадгаас өөр оюутанд хандсан судалгааны санхүүжилт бага.

Дүгнэлт: Төсөл хөтөлбөр түүнтэй холбоотой судалгаанд хамруулах.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**Шаардлага:**

- Хөтөлбөрөөр суралцагчдад зориулсан судалгааны санхүүжилтийн талаар тодорхой бодлого, дүрэм журмын дагуу зохицуулалт хийдэг байх, улмаар санхүүжилтийн нөөцтэй байх, судалгааны ажилд гэрээ байгуулж, магистрантыг албан ёсоор оруулахад дэмжих.

3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Ажил олгогчтой хийсэн уулзалтын тэмдэглэл, санхүүгийн баримт.
- ШУТИС-ийн захирлын 2022 оны 4 сарын 27-ны А/136 тоот “ШУТИС-ийн суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам”

Онцлог зүйл:

- Ажил олгогч болон бусад дэмжигч байгууллага болон ШУТИС-аас тэтгэлэг олгодог.

Дүгнэлт: Тэтгэлэг, тэтгэмж авах журмыг хэрэгжүүлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- Төслийн болон судалгааны багуудын тайлан.
- МХТС-ийн сургууль Холбооны салбар эрдэм шинжилгээ судалгааны 4-н профессорын багтай.

Онцлог зүйл:

- Улсын болон олон улсын чанартай төсөл хөтөлбөр хэрэгжиж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Магистрын хөтөлбөрт суралцаж байгаа оюутнаас судалгааны төсөлд үндсэн болон хавсран гүйцэтгэгчээр ажиллахад анхаарч, дэмжих.

Дүгнэлт: Багш нарын судалгааны ажил тогтмолжсон.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Магистр суралцагчийг хамруулах тал дээр анхаарах.
- Инновацийн судалгааны үр дүн гаргаж байгаа бүтээлийг бодлогоор дэмжих /тэтгэлэг, санхүү, бодит хэрэглээ болгох г.м./

3.7 Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- БШУС-н 2021 оны А/417 тоот тушаал, ШУТИС-ийн сургалтын журам түүний өөрчлөлт.

Онцлог зүйл:

- Судлаач магистрын төгсөлтийн шаардлага тодорхой байдаг. Магистрын төгсөлтийн ажил бичих стандарт мөрддөг.
- Төгсөлтийн ажил, хамгаалалттай холбоотой сөрөг санал гомдол гарч байгаагүй.

Анхаарах асуудал:

- Жинхэнэ хамгаалалтад дээр гарсан санал шүүмжийн дагуу ажлыг засаж сайжруулахад оноо, үнэлгээ өгөхгүй байгаа учир түүнд тавих хяналтыг хэн хийдэг талаар тодорхой болгох.

Дүгнэлт: Журмын дагуу хамгаалалт явагддаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Удирдагч багшийн хийж буй судалгааны баг, хамтлагийн хүрээнд хийгдэж гарсан үр дүнгээс магистрын судалгаанд тэр дундаа дипломын ажилд тусгасан бол дипломын ажлын “талархал” хэсэгт энэ талаар бичиж хэвших.

3.8 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, үр чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичиг, ШУТИС-ийн төгсөлтийн журам.

Онцлог зүйл:

- Стандартын дагуу баримт бичгийг олгодог. Нэмэлтээр судалсан хичээл болон түүний кредитийг дипломын хавсралт дээр тусгаж өгдөг.

Анхаарах асуудал:

- Хувь оюутны чадамж, мэргэжлийн өсөлт хөгжилт хандлага зэргийг дипломын удирдагч эсвэл зөвлөх багш илүү тодруулан тодорхойлж өгдөг байх.

Дүгнэлт: Төгсөлтийн баримт бичиг журмын дагуу олгогддог.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Элсэлтээс төгсөлт хүртэл суралцах хугацаа сунжирдаг байдлыг засахад чиглэсэн ажил хийх. Суралцах хугацаа урт болох нь тухайн суралцагчийн хандлагыг илэрхийлэх үзүүлэлт байх магадлалтайг тооцох.

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1 Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Захирлын 2021 оны 12 сарын 14 өдрийн А/232 тоот тушаалаар хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 13 өдрийн 10 дугаар тогтоолын батлагдсан ШУТИС Хүний нөөцийн бодлого 2023-2030
- Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага
- Багш нарын уулзалтын үр дүн
- Сургалт семинар зохион байгуулсан ажлын төлөвлөгөө, тайлан 2018-2023 он

Онцлог зүйл:

- “Утасгүй холбооны инженерчлэл” магистрын хөтөлбөрийг 100 хувь доктор зэрэгтэй багш нар сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- Багшийн нөөцийн асуудлыг сургуулийн хүний нөөцийн бодлогоор төлөвлөн, бэлтгэсэн.
- Сүүлийн 5 жилийн байдлаар Инженер технологийн дээд боловсрол MJEED 1000 төслийн хүрээнд гадаадаас 4 зочин профессорыг урьж хамтарсан сургалт семинарыг зохион байгуулсан. Тус сургалтад давхардсан тоогоор 92 багш хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Профессор, багш нарын үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг сурталчлан таниулах байдал дутмаг байгааг анхаарах.
- Багш, магистрантын тооны харьцааг зохистой байлгахад бодлогын түвшинд дэмжих

Дүгнэлт: ШУТИС-ийн хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хүрээнд удирдан зохион байгуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг тус хөтөлбөрт урьж ажиллуулах.

4.2 Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн үр чадварыг шударга, бодитой, системтэй,

тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2018 оны 08 сарын 23 өдрийн А/159 тоот тушаалаар “Багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”
- ШУТИС-ийн профессор багш нарын аттестатчилал, түүний үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг захирлын 2013 оны 11 сарын 15 өдрийн А/213 тоот тушаалаар баталсан.
- ШУТИС-ийн профессор багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам 2021
- ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах журам -2016
- Багш нарын уулзалтын үр дүн

Онцлог зүйл:

- Багшийн тухайн хичээлийн жилд нормоос давсан сургалт, эрдэм шинжилгээ, инновацын ажлын гүйцэтгэлийг илүү кредит цагаар тооцож олгодог. Сүүлийн 4 жилийн байдлаар 240.454 илүү кредитийн хөлсийг давхардсан тоогоор 72 багшид олгосон байна.
- Багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, дүгнэх зорилгоор хичээлийн жилд 2 удаа үр дүнгийн урамшуулал ажлын гүйцэтгэлд үндэслэн зохих журмын дагуу олгодог. 2018 -2021 оны хооронд уг урамшууллыг давхардсан тоогоо 95 багш авсан, 2021 оноос хойш цар тахлын үед нийт багш нарт 10 % урамшуулал үндсэн цалин хөлс дээр сар бүр нэмж олгох хамтын ажиллагааны журам гарсан байна.
- Сүүлийн 3 хичээлийн жилд багш, ажилтны цалин 5 удаа 5%-аас 15 % -иар тус тус нэмэгдсэн байна.
- Улирал бүрийн төгсгөлд багш нар заасан хичээлийн тайлан бичиж хичээлийн явцаа нэгтгэн дүгнэдэг.

Анхаарах асуудал:

- Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоог бүрдүүлэхэд багшийн байнгын хөгжлийг дэмждэг бодлого, төлөвлөгөөтэй байх.

Дүгнэлт: Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг төв болон салбар сургуулийн үйл ажиллагаанд нийцүүлэн үнэлэх тогтолцоо бүрдсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Үр дүнгийн урамшуулал олгох бодлого тогтвортой, тодорхой журамтай байх

4.3 Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инновац нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2021 оны 12 сарын 22 өдрийн А/243 тоот тушаалаар батлагдсан Багшийн хөгжлийн хөтөлбөр.
- ШУТИС-ийн МХТС-ийн захирлын 2023 оны 08 сарын 14 өдрийн А/39 тоот тушаалаар байгуулсан Багшийн хөгжлийн багийн бүрэлдэхүүний тушаал.
- ШУТИС-ийн профессор багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам -2019 он
- ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах журам -2016
- Сүүлийн 2 жилийн багш хөгжлийн үйл ажиллагааны төсвийн санал, гүйцэтгэлийн тайлан.

Онцлог зүйл:

- Багшийн хөгжлийг дэмжих бодлогын бичиг баримттай.
- Жил бүрийн төсөв дээр жилд дунджаар 110 сая төгрөгийг багшийн хөгжил дээр төсөвлөдөг.
- ШУТИС нь багшийн хөгжлийг дэмжих, системтэйгээр зохион байгуулах олон шатлалт бодлогын бичиг баримттай.
- Хөтөлбөрт хамаарах багш нар өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр гадаадад сургалт, семинарт хамрагддаг. ӨҮТ-д Багш нарын сургалтад хамрагдсан байдлыг авч үзвэл гадаад сургалтад давхардсан тоогоор 14 багш, дотоод сургалтад 2 багш хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжил, багшийн сургах, хөгжих хэрэгцээг тухайлан судалсан судалгааг хийдэггүй байна.
- Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр төслийн хүрээнд ажлууд хийгдсэн хэдий ч багшийг хувь хүн талаас нь өөрийг нь хөгжүүлэх, мэдлэг бүтээх, техникийн мэргэжил учраас инновац нэвтрүүлэх тал дээр дэмжлэг үзүүлбэл ач холбогдолтой.

Дүгнэлт: Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй нэвтрүүлэхийг сайн дэмжин ажилладаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшийн сэтгэл ханамжийн судалгааг холбооны салбар сургууль тухайлан авч судлах, үр дүнд тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж, үнэлж дүгнэдэг байх.

4.4 Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, инновацын холбогдох мэдээлэл, дүрэм, журам <http://www.sict.edu.mn/mn/163/165>
- ШУТИС-ийн профессорын баг, тэнхимд тавигдах шаардлага
- ШУТИС-ийн Стратеги төлөвлөгөө 2030
- Захиалгат төслийн хамтран ажиллах гэрээнүүд

- Гэрээт судалгааны тайлангууд.

Онцлог зүйл:

- Хамтын ажиллагааны хүрээнд 27 газартай гэрээ хийж, сургалт эрдэм шинжилгээ, нийгмийн ажлын хүрээнд хамтран ажилладаг байна.
- Сүүлийн 5 жилд сургуулийн хэмжээнд Улсын захиалгат судалгааны ажлын гэрээг суурь судалгаа, технологийн туршилт, гадаад, дотоод хамтарсан, инновацын гэсэн чиглэлээр нийтдээ 7 төсөл хэрэгжүүлж, судалгааны 383.160.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.
- Профессор багш нарын удирдлага дор судалгааны 4 баг бүрдүүлж, магистрантуудыг тодорхой хэмжээнд дотоодын төсөл дээр татан оролцуулсан байна.
- Профессор, багш нарын бүтээл оюуны өмчөөр баталгаажсан.
- Багш нарын сургалт, судалгааны ажил, заах арга зүйн 3 үндсэн чиглэлд 5G хөдөлгөөнт холбоо ба утасгүй сүлжээний нэгдэн нийлэлт судалгаан багийн үр дүнгээр 14 удаагийн сургалт, семинарыг зохион байгуулсан.
- Сургуулийн стратеги төлөвлөгөөнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлийг Төв ШУТИС-ийн Стратеги төлөвлөгөө 2030-ийн тэргүүлэх чиглэлийн 2 болон 3 дах хэсэгт тусгагдсан. Тус стратеги төлөвлөгөөний дагуу ХМТС мастер төлөвлөгөө бэлтгэгдсэн байна.

Дүгнэлт: Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, судалгааны багуудын хүрээнд магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Анхаарах асуудал:

- Судалгааны тодорхой чиглэлээр багш нарыг мэргэшүүлэх, бодлогоор дэмжих.
- Хамтын ажиллагааны хүрээнд 27 газартай гэрээ хийж, сургалт эрдэм шинжилгээ, нийгмийн ажлын хүрээнд хамтран ажилладаг байна. Гэрээний дагуу хийсэн ажлыг дүгнэх, үнэлэх, нэгтгэх.
- Үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байх.

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

5.1 Сургалт, судалгааны орчин

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулах өөрийн хичээлийн тусдаа байр, анги танхим, лаборатори орчин.

Онцлог зүйл:

- Олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрөөр тоноглогдсон анги, танхим, лабораторитой.
- Ажил олгогч болон хамтын ажиллагаатай байгууллагуудын хөрөнгө оруулалт хийгддэг.
- Тоног төхөөрөмжүүд шинэчлэгддэг.

Анхаарах асуудал:

- Зайн сургалтаар хичээл явагдах тохиолдол их байдаг тул суралцагчид зарим тохиолдолд тухайн тоног төхөөрөмжийг ашиглахгүй байх магадлалтай.

Дүгнэлт: Сургалт, судалгааны орчин хангалттай сайн бүрдсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Магистрын болон ахисан түвшинд сургалт болон судалгаанд ашиглах орчныг илүү тодруулж өгөхөд анхаарах.

5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сан, лабораторид ашиглаж байгаа программ хангамж, teams болон moodle сан дээрх хичээлийн материалууд. ШУТИС болон МХТС-ийн тайлангууд.

Онцлог зүйл:

- Суралцагч нар зайнаас суралцах хэлбэр түгээмэл тул цахим эх үүсвэр ашигладаг. Багш нарын хичээлд ашиглах сан хөмрөг хангалттай.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэх материалуудыг тодорхой болгох шаардлага байна. Үүнд симуляц программ хангамж, үндсэн сурах бичиг Монгол хэл дээр, IEEE судалгааны сангаас мэдээлэл үзэх, хуулбарлалтын программ хангамж нэвтрүүлж хэвших.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Багш нарын хичээлд ашиглаж байгаа эх сурвалжийг Moodle, Teams дээрх хичээлд оруулж өгөх. Өөрөөр хэлбэл references хийх, эх сурвалж оруулах.
- 32 программ хангамж тайланд тусгасан байна. Тэдгээрээс 3 нь албан ёсны лиценз эрхтэй байна. Иймд үнэ төлбөргүй ашигладаг opensource болон яг тус хөтөлбөрт тогтмол ашиглаж байгаа ПХ-г тодорхой болгох.

5.3 Төсөв, санхүүжилт

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-н 2017-2018 /246 хуудас/, 2018-2023 оны хичээлийн жилийн МХТС-н тайлангууд.
- ШУТИС-н А/248 тоот тушаал “Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журам”.

Онцлог зүйл:

- Орлого зардлын харьцаа хэвийн. 76%-н гүйцэтгэлтэй.
- Нэг оюутанд ноогдох зардал тооцоход 2018 онд МХТС-н дундаж 1972300 төгрөг байна. Удирдах зөвлөлийн тогтоосон 1780200 төгрөгөөр тогтоосон сургалтын төлбөрөөс өндөр байна.
- Олон улсын байгууллага, их сургуультай хамтарсан төслүүд хэрэгждэг. Жишээлбэл 6 сая долларын санхүүжилттэй KOICA, SMU төсөлд нийт 39 багш профессор хамрагдсан.
- 2023 онд 88.1% болж өссөн.
- Мэргэжлийн зэрэг ахиулахад магистр болон түүнээс дээш боловсролын зэрэг ахисан байхыг шаарддаг болсон нь суралцагч элсэх суурь нөхцөл болж өгсөн.

Дүгнэлт:

Гадаад болон дотоодын төслийн хөрөнгө оруулалт хангалттай ерөнхий санхүүгийн байдал эерэг боловч тус хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх болон хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөв тодорхой биш байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутны тоо цөөрч байгаа нь нэг оюутанд ноогдох өртөг зардалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Иймд суралцагчийн тооны доод хязгаарыг тодорхойлж өгөх.

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

6.1 Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 01-р сарын 12-ны 02 тоот тогтоол “ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрэм”

- ШУТИС-ийн Захирлын 2023 оны 1 дүгээр сарын 12-ны А/12 тоот тушаал Бүрэлдэхүүн сургуулийн бүтэц, бүрэлдэхүүн
- Эрдмийн зөвлөлийн 2023/6/13-ны 10 дугаар “ШУТИС-ийн хүний нөөцийн бодлогыг батлах тухай” тогтоол
- ШУТИС-ийн Захирлын 2021 оны 12-р сарын 24-ны А/246 тоот тушаал “ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм”

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд удирдлага, засаглалын тогтолцоо бүрдсэн.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг тогтолцоо бүрдсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

6.2 Ажилтнууд

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих үр чадвар, туршлагатай байна.

Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Захирлын 2011/5/2-ны өдрийн А/97 тоот “ШУТИС-ийн багш ажилтныг орон сууцны зээлд хамруулах үйл ажиллагааг зохицуулах журам”, Эрдмийн зөвлөлийн 2023/6/13-ны 10 дугаар “ШУТИС-ийн хүний нөөцийн бодлогыг батлах тухай” тогтоолоор зохицуулагддаг.
- Багшийн хөгжлийн төвөөр дамжуулан ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулсан тайлан.

Онцлог зүйл:

- Салбар сургуулийн сургалтын мастер 1, сургалтын албаны магистрын сургалт хариуцсан 1, чанарын албаны 1, хүний нөөц, санхүү, номын санч тус тус 1, 1 мэргэжилтэн ажиллаж байна.
- Багшийн хөгжлийн төвөөр дамжуулан ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулдаг.

Анхаарах асуудал:

- Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэхэд удирдлагын зүгээс дэмжсэн талаарх мэдээлэл, тайлан дутмаг байв.

Дүгнэлт: Хүний нөөц, үр чадвар, туршлага, өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролыг дэмжих бодлогын баримт бичгүүдийг боловсруулан түүнийг баримтлан ажилладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэхэд удирдлагын зүгээс дэмждэг байхад анхаарах.

6.3 Удирдлагын мэдээллийн систем

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Их сургуулийн UNIMIS Удирдлагын мэдээллийн 2003 онд анх ашиглалтад оруулсан
- МХТС нь дотоод үйл ажиллагаандаа ашигладаг Click Up платформын ашиглалт.

Онцлог зүйл:

- Их сургуулийн UNIMIS Удирдлагын мэдээллийн систем болон “Сургалтын процессын удирдлага” дэд системийг ашигладаг. Дэд системүүд нь сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээ хоорондоо дамжуулдаг, хардаг, солилцдог зэрэг олон боломжтой.
- МХТС нь дотоод үйл ажиллагаандаа Click Up платформыг ашиглалт сайн.

Анхаарах асуудал:

- UNIMIS-д цугласан датад дүн шинжилгээ хэрхэн хийж, хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг эсэх нь тодорхой бус
- Click Up платформыг дотоод үйл ажиллагаандаа ашигладаг нь мэдээллийг цуглуулах, түргэн шуурхай дамжуулах, санал солилцох боломжийг бүрдүүлдэг юм байна. Уг платформ дээрх мэдээллийн үр дүнг үнэлэх, баримтжуулан сайжруулахад анхаарах

Дүгнэлт:

- Сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад чиглэсэн удирдлагын мэдээллийн системтэй ба тухайн системээр дамжуулан хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаанд бүх талаар бүрэн ашигладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Удирдлагын мэдээллийн системд цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийг сайжруулахад анхаарах.

6.4 Мэдээллийн ил тод байдал

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн динамик www.must.edu.mn
- Мэдээлэл, холбоо технологийн сургуулийн www.sict.edu.mn
- <https://www.sict.edu.mn/>, <https://www.sict.edu.mn/mn/228/196>
- Төгсөгч, ажил олгогчийн мэдээлэл солилцох цахим групп

Онцлог зүйл:

- <https://www.sict.edu.mn/> веб хуудас шинэчлэл хийгдэж байгаа.

Анхаарах асуудал:

- www.sict.edu.mn тус сайтад магистрын сургалтын үйл ажиллагаа, онцлогийг тусгасан мэдээллийн агуулгыг нэмэгдүүлэх.
- Тухайн хөтөлбөрийн мэдээлэл танилцуулга веб хуудас байхгүй байна.

Дүгнэлт: Тухайн хөтөлбөрийн танилцуулга, хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчдад нээлттэй хүргэж, тогтмол шинэчлэлтийг хийх ажлыг хэрэгжүүлэхэд анхаарч байна

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Ажил олгогчийн цахим уулзалтаас инженерийн салбарын мэргэжлийн боловсон хүчний эрэлт их боловч нийлүүлэлт бага байгаад анхаарч өгөх, мэргэжлийн сурталчлан таниулах ажлуудыг эрчимтэй зохион байгуулахад анхаарах
- Элсэгчийг татах, нэмэгдүүлэх байдлыг бодлогоор дэмжиж, шатлан суралцах боломж, нөхцөлийг хангах хэрэгтэй.

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

7.1 Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөгчдийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн үнэлгээний ерөнхий загвар, аргууд
- Чанарын дотоод баталгаажуулалтын процесс, үйл явц
- Оролцогч талуудын судалгаа, үр дүн
- Салбарын хувьд дотроо 7 үйл ажиллагааны дэд зөвлөл байдаг. (АВЕТ тайлан 2018) Сургалтын хөтөлбөр хариуцсан дэд зөвлөл нь шууд бус үнэлгээг хариуцан хийнэ.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын тогтолцоо нь СХХДЗ үйл ажиллагаанд хамаарч явдаг. Сургалтын алба дээр чанар хариуцсан ажилтан байна.
- Суралцахуйн үр дүнгийн судалгааг эмх цэгцтэй, үе шаттай хийдэг нь нотлох баримтуудаар харагдаж байв.

Анхаарах асуудал:

- Оролцогч, сонирхогч талуудаас авсан судалгааны эцсийн үр дүнг тайлан болгон баримтжуулах, үнэлэх, улмаар судалгааны үр дүнд анализ хийж, үр дүнд нь хөтөлбөрт сайжирдаг байх тогтолцоог нэвтрүүлэх, тогтмолжуулахад анхаарах хэрэгтэй байна.
- ШУТИС-ийн нэгдсэн чанарын удирдлагын тогтолцоо нь ахисан түвшний хөтөлбөр уялдаа холбоог сайжруулах.

Дүгнэлт: Хөтөлбөрийн хэрэгжилтийг тодорхой үе шат давтамжтайгаар хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байхад анхаарах.
- Оролцогч талуудын судалгааг хичээлийн жил бүрээр гаргаж, тайлан болгож боловсруулах шаардлагатай.

7.2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөө, тайлан
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн.
(МХТС-ийн захирлын 2020.02.18-ны 2/054 тоот албан бичиг: Мэдээлэл, холбооны технологийн чиглэлийн байгууллага-ажил олгогчид руу санал авах тухай албан бичиг).
- Төгсөгчийн мөшгөх судалгааны үр дүн.
- Дотоод, гаднын байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн тайлан, үр дүн

Онцлог зүйл:

- Холбооны салбарын ахисан түвшний магистрын 3 хөтөлбөр магадлан итгэмжлэлийн хүсэлт гарган, өөрийн үнэлгээний тайланг бичиж, БМИҮЗ-ийн мэргэжлийн шинжээчийн баг ажиллуулсан байна.
- Жил бүр хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шууд ба шууд бус үнэлгээг хийж, сайжруулахад анхааран ажилладаг байна.
- “Утасгүй холбоо” бакалаврын хөтөлбөр нь 2017-2018 оны хичээлийн жилд АНУ-д төвтэй инженер технологийн олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага – АБЕТ-аар магадлан итгэмжлэгдсэн. (АБЕТ – Accreditation Board of Engineering Technology)

Анхаарах асуудал:

- Оролцогч, сонирхогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан, мэдээллийг үе шаттай цэгцтэй гүйцэтгэж, баримтжуулдаг байх.

Дүгнэлт: Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын жишигт хүрэхийг эрмэлзэж ажиллахад анхаардаг байх.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оролцогч, сонирхогч талуудын судалгааны үр дүнгийн боловсруулалт, мэдээллийн баазыг баримтжуулан бүрдүүлдэг байхад анхаарах

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн зорилго, агуулга	5x2			
2	Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	5x2			
3	Суралцахуйн үнэлгээ, хөгжил	6 x 2	2x1		
4	Багшлах бүрэлдэхүүн	4x2			
5	Нөөц ба санхүүжилт	3x2			
6	Удирдлага ба мэдээллийн систем	4x2			
7	Чанарын баталгаажуулалт	7x2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн “Утасгүй холбооны инженерчлэл” магистрын хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, инженерийн үйлдвэрлэлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх комисст хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:

Б.Оюунсүрэн

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

Р.Мижиддорж

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

Д.Сумъяаханд

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Утасгүй холбооны инженерчлэл
Хөтөлбөрийн индекс	E071408
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт хяналт шинжилгээ хийсэн үр дүн болон оролцогч талуудын санал, зөвлөмжийг хөтөлбөрийг сайжруулахад хэрхэн тусгасан талаар баримтжуулан, хяналтыг тогтмолжуулах. - Мэргэжлийн болон судалгааны магистрын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хөтөлбөрийн онцлогийг тусгаж ялгаатай тодорхойлох. - Олон улсад тухайн хөтөлбөрт ямар тусгай шаардлагуудыг тавьж байгааг судалж баримтжуулан, хэрэгжүүлэх боломжтой үр дүнтэй аргуудыг туршиж, хэрэгжүүлэх.
Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> - Орчин үеийн шинэлэг арга хэрэгсэл турших, олон улсын туршлага судлах гэх мэт багшлахуйн арга зүйг сайжруулах тодорхой ажлуудыг төлөвлөж, тогтмол хийх. - Магистрант анх элсэхдээ сонгосон сэдэв, хийсэн төлөвлөгөөнд удирдагч тогтмол хяналт тавьж, магистрантыг идэвхижүүлж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг өөрчилж, магистрантыг төлөвлөсөн хугацаандаа, чанартай судалгааны ажил хийж дуусахад нь дэмжлэг үзүүлэх. - Магистрантын бүтээлч ажлыг дэмжих, үнэлэх, урамшуулах тодорхой тогтолцоог боловсруулж, хэрэгжилтийг хангах.
Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	<ul style="list-style-type: none"> - PLOs хэт ерөнхий байгаа нь суралцахуйн үнэлгээ, хөгжлийг ерөнхий үнэлэх сөрөг талтай тул цаашид утасгүй холбооны мэргэжлийн онцлог тусгах. - Бакалаврын түвшинд хэрэгжиж хэвшсэн ажлуудыг магистрын түвшинд хэрэгжүүлж хэвших.
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг тус хөтөлбөрт урж ажиллуулах - Багшийн сэтгэл ханамжийн судалгааг холбооны салбар сургууль тухайлан авч судлах, үр дүнд тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж, үнэлж дүгнэдэг байх.
Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт	<ul style="list-style-type: none"> - Багш нарын хичээлд ашиглаж байгаа эх сурвалжийг Moodle, Teams дээрх хичээлд оруулж өгөх. Өөрөөр хэлбэл references хийх, эх сурвалж оруулах.

	<ul style="list-style-type: none"> - Гадаад болон дотоодын төслийн хөрөнгө оруулалт хангалттай ерөнхий санхүүгийн байдал эерэг. Гэвч тус хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх болон хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөв тодорхой болгох.
Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийг нийтэд сурталчлан таниулах, мөн тус хөтөлбөрт элсэгчийг татах, нэмэгдүүлэх
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> - Оролцогч, сонирхогч талуудын судалгааны үр дүнгийн боловсруулалт, мэдээллийн баазыг баримтжуулан бүрдүүлдэг байхад анхаарах - Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байхад анхаарах.
ШААРДЛАГА:	
Шалгуур 3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт	<ul style="list-style-type: none"> - Суралцахуйн зорилт хэт ерөнхий байгаа нь үр дүнд амжилттай хүрсэн эсэх шалгуур нь бусад хөтөлбөрүүдтэй адилхан байна. Яг энэ хөтөлбөрийн онцлогийг харуулсан PLO тодорхойлж түүндээ хүрч байгаа эсэхийг шалгадаг байх.
Шалгуур 3.4 Судалгааны санхүүжилт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрөөр суралцагчдад зориулсан судалгааны санхүүжилтийн талаар тодорхой бодлого, дүрэм журмын дагуу зохицуулалт хийдэг байх, улмаар санхүүжилтийн нөөцтэй байх, судалгааны ажилд гэрээ байгуулж, магистрантыг албан ёсоор оруулахад дэмжих.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Эрдмийн зэрэг цол	Ажилласан жил		
					Төрд	Багшаар	МХТС
1	Ц.Балжинням	Салбарын профессор	F.CNM707 Холбооны системийн тоон дохионы боловсруулалт. F.CNM716. Мэдээлэл, холбооны салбарын стандарт, бодлого, зохицуулалт	Доктор, дэд профессор	28	28	28
2	Ж.Жавзансүрэн	Салбарын профессор	J.RC760-Судалгааны ажлын семинар I J.RC767-RF системийн инженерчлэл ба хийц	Доктор, дэд профессор	35	31	31
3	Ш.Ганболд	Салбарын дэд профессор	J.*762 Судалгааны ажлын семинар III. J.CN702. Тоон холбооны дэвшилтэт систем. J.OC763. Дараа үеийн оптик сүлжээ	Доктор, дэд профессор	27	8	8
4	Л.Эрдэнэбаяр	Салбарын дэд профессор	J.CN701. Системийн загварчлал ба симуляци. F.CNB705 Бичил долгионы хэлхээ ба систем дизайн.	Доктор	13	12	13
5	С.Батдалай	Салбарын дэд профессор	J.TC768. Цахилгаан холбооны тусгай сэдвүүд	Доктор	13	11	13
6	Б. Пүрэвцэрэн	Салбарын дэд профессор	F.CNM706. Утасгүй сүлжээний төлөвлөлт ба дизайн	Доктор	14	14	14
7	А.Мөнхбаяр	Ахлах багш	J.TC766. Өргөн зурвасын сүлжээ	Доктор	13	13	13
8	Р.Баярмаа	Ахлах багш	F.CNM704. Цахилгаан соронзон нөлөөлөл ба зохицол	Доктор	18	16	18
9	Э.Нарантуяа	Ахлах багш	F.CNM711. Радар, навигацын технологи	Доктор	34	32	32
10	Ч.Оюу	Ахлах багш	F.CN304. Долгион тархалт ба антенн, F.CN303 Аналог, тоон холбооны систем	Доктор ант	20	20	20
11	Б.Оюун-Эрдэнэ	Сургалтын мастер	Лаборатори хариуцдаг	Магистр	24		14

II. Оюутны нэрс

№	Оюутны код	Овог нэр	Харьяалал	Одоогийн албан байгууллага	Одоогийн албан тушаал
1	J.RC17E105	М.Долгор	Улаанбаатар	ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төв	Нисэхийн журам боловсруулалтын албаны шалгагч инженер
2	J.RC19E006	Э.Энхболд	Улаанбаатар	ИНЕГ, ИНУТ, Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар	Ахлагч инженер
3	J.RC19E021	А.Дариймаа	Сэлэнгэ	МХС ТӨХК-ийн Сэлэнгэ аймгийн холбооны газар	Сүлжээний инженер
4	J.RC20E005	Б.Эрдэнэбаяр	Улаанбаатар	Техник сургалт судалгааны төв ХХК	Элеектроникийн инженер
5	J.RC21E012	Н.Баяраа	Өмнөговь	МХС ТӨХК-ийн Өмнөговь аймгийн холбооны газар	Газрын дарга
6	J.RC21E050	Т.Мөнгөнзул	Улаанбаатар	Time сайт ХХК	Мэдээний оператор
7	J.RC21E050	Ц.Цолмон-Од	Улаанбаатар	Юнитель групп ХХК-ийн Техникийн газрын мобайл сүлжээ ашиглалтын алба	Дамжуулах сүлжээний инженер
8	J.RC21E051	Д.Бат-Отгон	Дорноговь	Улаанбаатар Төмөр Зам	Дохиолол холбооны 3-р ангийн ашиглалт хариуцсан орлогч дарга
9	J.RC22E003	А.Батнягт	Улаанбаатар	Ниттон девелопмент ХХК	Кабелийн техникч
10	J.RC22E005	П.Уранцэцэг	Улаанбаатар	ZTE ХХК	Инженер
11	J.RC22E006	Б.Тунгалаг	Улаанбаатар	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Бодлого төлөвлөлтийн мэргэжилтэн
12	J.RC23E001	Ж.Лувсанням	Хөвсгөл	МХС ТӨХК-ийн УБ Хөвсгөл аймгийн холбооны газар	Ерөнхий инженер
13	J.RC23E003	Б.Баасанцэрэн	Улаанбаатар	Төрийн тусгай хамгаалалтын газар	Ахлах инженер
14	J.RC23E004	З.Бямбасүрэн	Хөвсгөл	МХС ТӨХК-ийн УБ Хөвсгөл аймгийн холбооны газар	Сүлжээний инженер

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Байгууллага
1	Т.Наранмандах	Хуралдааны НБД	Харилцаа Холбооны Зохицуулах хороо
2	Д.Ариунзул	Хүний нөөц, дотоод сургалт хариуцсан ахлах шинжээч	Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам

3	Г.Нямжав	Техник технологийн ашиглалтын газрын дарга	Монголын Цахилгаан Холбоо ХК
4	Д.Мянганбаатар	Захиргаа, удирдлагын газрын дарга	Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК
5	Я.Батжаргал	Технологийн газрын захирал	Скайтел ХХК
6	Ж.Булгантамир	Скайнетворс ХХК-ний дамжуулах сүлжээний алба	Ахлах инженер.
7	Б.Түвшинжаргал	Техникийн Төлөвлөлтийн Албаны менежер	Мобиком корпораци ХХК
8	Э.Төрбаяр	Төвийн дарга	ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төв
9	Б.Галбадрах	Техникийн бодлого төлөвлөлтийн газрын дарга	Радио телевизийн үндэсний сүлжээ улсын төсөвт үйлдвэрийн газар
10	Ч.Сэлэнгэ	Дохиолол холбооны албаны холбоо хариуцсан ахлах инженер	Улаанбаатар Төмөр Зам Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг
11	П.Нямравдан	Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба	Холбооны хэлтэсийн дарга, цагдаагийн хурандаа
12	Ц.Баясгалантөгс	Энжинэкс ХХК	Гүйцэтгэх захирал
13	Д.Наранчулуун	Технологи хариуцсан захирал	Грийн Софт ХХК
		Гүйцэтгэх захирал	Интеллигент Технологи Партнер ХХК
14	Н. Болорхүү	Төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч	МҮОНТВ-ийн Техникийн төв
15	Н.Пүрэвжав	Ашиглалт зохицуулалтын хэлтсийн дарга	Монгол телевиз ХХК

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэр	Төгссөн огноо	Одоогийн албан байгууллага	Одоогийн албан тушаал
1	Б.Баттулга	2015.06.	<i>Харилцаа холбооны зохицуулах хороо</i>	<i>Хөдөлгөөнт хяналтын ахлах инженер</i>
2	Б.Эрхэмбаяр	2017.01.	<i>ДДэш ТВ ХХК</i>	<i>Технологи төлөвлөлтийн хэлтэсийн менежер</i>
3	М.Эрдэнэцэцэг	2018.01.	<i>Харилцаа холбооны зохицуулах хороо</i>	<i>Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн</i>
4	Б.Уянга	2019.06.	<i>Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төвийн Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар</i>	<i>Агаарын навигацгийн техникийн үйлчилгээний аюулгүй байдлын технологич мэргэжилтэн</i>
5	Г.Мөнхдэлгэр	2020.01.	<i>ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төвийн Холбоо навигацын ажиглалтын алба</i>	<i>Ээлжийн инженер</i>
6	Д.Уртнасан	2021.01.	<i>ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төв</i>	<i>Ерөнхий менежер</i>

7	Х.Алтан-Эрдэнэ	2021.01.	<i>ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төвийн Холбоо навигацын ажиглалтын алба</i>	<i>Ээлжийн ахлагч инженер</i>
8	М.Баасанжаргал	2021.06.	<i>Мобиком корпорац ХХК-ний Дамжуулах байгууламж алба</i>	<i>Инженер</i>
9	Э.Отгонзаяа	2021.06.	<i>Мобиком корпорац ХХК</i>	<i>Сүлжээ ашиглалтын хэлтэсд инженер</i>
10	Р.Цагаанхүү	2021.06.	<i>ИНЕГ, ИНУТ, Нисэхийн Холбоо, Навигац, Ажиглалтын Алба</i>	<i>Ээлжийн ахлагч инженер</i>
11	Ж.Гэрэлт-Од	2022.01.	<i>МХС ТӨХК-ийн Дамжуулах сүлжээ ашиглалтын газрын</i>	<i>Дотоод сүлжээний хэлтсийн програм хангамжийн инженер</i>
12	П.Гэрэлтцэцэг	2022.01.	<i>Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын</i>	<i>Радио давтамжийн хуваарилалт, бүртгэлийн мэргэжилтэн</i>
13	Б.Батцэцэг	2022.01.	<i>Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын</i>	<i>Судалгаа шинжилгээ дотоод ажил хариуцсан мэргэжилтэн</i>
14	Э.Наранцэцэг	2022.01.	<i>Харилцаа холбооны зохицуулах хороо</i>	<i>Шуудан зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн</i>
15	Т.Мягмаржав	2023.01.	<i>Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, Шуурхай Удирдлагын Төв</i>	<i>Техник ашиглалтын тасгийн инженер</i>
16	Ч.Анхцацрал	2023.01.	<i>УБ ТЗамын дохиолол холбооны 3-р анги</i>	<i>Радио холбооны инженер</i>
17	А.Оюун-Эрдэнэ	2023.06.	<i>ИНЕГ-ХНАА</i>	<i>Навигацийн инженер</i>
18	А.Болортуяа	2024.01.	<i>Харилцаа холбооны зохицуулах хороо</i>	<i>Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын ахлах мэргэжилтэн</i>

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



ШИНЖЛЭГЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ
ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

13343 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
Утас/Факс: (976) 7015 1333, И-мэйл: sict@must.edu.mn,
Вебсайт: www.sict.edu.mn

2024.02.29 № 1/066


танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

ШУТИС-ийн МХТС-ийн E071408 индекстэй “Утасгүй холбооны инженерчлэл”-ийн магистрын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, шаардлагатай санал нийлж, хүлээн зөвшөөрч байгааг үүгээр илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Н.ЧУЛУУНБАНДИ